

БОГД ГЭГЭЭНТЭН ОРОС УЛСААС ХЭДЭН УДАА ТУСЛАМЖ ХҮССЭН БЭ?

(Асуудлыг нягтлахуй)

З.Лонжид. МУИС. НШУС. Түүхийн тэнхим

Өгүүллийн товч утга: XXIII дүрийн Жибзундамба хутагт Монголын тусгаар тогтнолыг сэргээн тунхаглахын төлөө их үйлсэд чин санаа тавьж 1800-аад оны сүүлч ба 1911 онд Хаант Орос улсад өөрийн бие төлөөлөгчдийг томилон илгээсэн тухай болон 1920 онд Монгол Ардын Намын анхны долоон хүн ЗОУ-д тусламжийн хэргээр одоход тэрбээр ямар байр суурьтай байсныг түүхчид бүтээл туурвилдаа хэрхэн тусгасныг энэ өгүүлэлд тодруулахыг хичээлээ.

Түлхүүр үг: Богд Жибзундамба, Бадамдорж, Белов, Цэрэн-Осор, Магсархурц, Шишмарев, Дилав хутагт, Сайн ноён хан, Петербург, Чимитдоржиев.

Монголчууд Манжийн эрхшээлээс ангижрахын төлөө олон жилийн турш тууштай тэмцэхэд ухаалаг ноёд, лам нар буюу ихэс дээдсийн тодорхой хэсэг удирдан манлайлж зохих үүрэг гүйцэтгэсэн билээ. Ялангуяа Богд гэгээнтэн 1895 буюу 1900, 1911 онд өөрийн элч төлөөлөгчдийг Хаант Орост илгээсэн ба 1920 онд Д.Сүхбаатар нарын ЗОУ-д тусламж гуйх бичигт нь тамгаа дарж өгсөн зэрэг нь өнгөрсөн зууны Монголын хоёр хувьсгалын түүх ба хорин гуравдугаар дүрийн Жибзундамбын улс төрийн үйл ажиллагааг шинжлэн судлахад онцгойлон авч үзэх зүйл мөн. Гэвч энэ талаар манай түүхчид тусгайлан судалж нийтийн хүртээл болгосон бүтээл одоогоор үгүй байгаа учир би энэхүү өгүүллийг тэрлэснээ эрхэм абугай Танаа толилуулж санал бодлыг тань сонсохыг хичээлээ.

Би энэхүү асуудалд шууд ба дам холбогдох баримт сэлтийг бүрэн хамарч чадаагүй нь мэдээж боловч урьд өмнө нь судалгааны эргэлтэнд ороогүй бололтой нэг сурвалж олж ашигласнаа энэ дашрамд өчье.

**Нэг. Н.Магсаржав, Л.Дэндэв, Б.Жамсранжав нарын
бүтээлд буй зарим мэдээ**

1880-аад оноос эхлэн Богд хутагтын дэргэд хорь гаруй жил түшмэлийн алба хашсан хурц гүн Магсаржав Монгол-Оросын улс төрийн харилцааны түүхэнд Богд хутагт ямар үүрэг гүйцэтгэснийг манай түүхчдээс анх удаа 1925 онд нэгэн бүтээлдээ цухас дурджээ.

Тэрбээр өгүүлэхдээ 1898 оноос эхлэн Манж дайчин Улс шинэ засгийн бодлогыг Монголд хэрэгжүүлж эхэлсэнд “Монголчууд нэн ч дурлахгүй Хятад

лугаа өс тэмцэл болж ... Богд Жибзундамба ... алт малтуулахгүй хэмээн шууд хөшөөлсний улам /улмаас/ Ли Яан Шуван /Их хүрээнд сууж байсан Манжийн сайд 3.Л/ нарын газраас Богдыг олон зүйлээр буруушааж Манж хаанаа айлтгав гэх зэргийн учраас улам бүр дайсан бололцож Хятадаас сайн арга олдох болов уу хэмээн Богд Жибзундамба хутагтаас Монголыг Чин улсаас салгаж, тусгаар улс байгуулахад тусламж эрээр да лам Бадамдорж, донир лам Цэрэн-Осор нарыг Петербург хотноо нууцаар зарж Оросын хаанд захиа бэлэг хүргүүлсэн зүйл буй боловч уг зорьсон хэрэг хойшилсон” /11.7/ гэжээ. Энэ бол Богд Жибзундамба Монголын тусгаар тогтнолын тухай асуудлаар анх удаа Орост хандсан түүхэн үйл явдал байлаа. Гэвч Н.Магсаржав уг үйл явдал чухам хэзээ хэдэн онд болсон, яагаад зохих үр дүнд хүрээгүйг ер дурдаагүй өнгөрсөн аж. Үүнийг бараг хэвээр нь давтан өгүүлсэн мэдээ түүхч Л.Дэндэвийн 1934 онд хэвлүүлсэн нэгэн бүтээлд бий. Тэрбээр бичихдээ “Манж-Хятадын эзэрхэг харгисын хэтэрхий дарлалуудыг олон онд эдэлж зовлон гашуун нь өрнөж тэсэшгүй болсон учир ...тэрхүү зовлон зүдүүрээс хэрхэн ангижрах арга замыг эрэлхийлж, Ар, өврийн олон монголчууд бичиг мэдээгээр харилцан нэвтрэлцэж ахуй цаг Богд Жибзундамба хутагтаас 1900 онд Да лам Бадамдорж, зайсан Цэрэн-Очир нарыг их Орос Улсын Засгийн газраа тусгай захидал бэлэг авахуулан явуулж тусламж хамгааллыг гуйсныг Орос Улсаас тэр даруйд хэрэг болгож үзсэнгүй хойшлуулсан зүйл буй /8.1/ гэжээ. Магсархурц, Дэндэв хоёрын бичсэн зүйл утгын хувьд үндсэндээ ижил боловч Цэрэн-Очир, Цэрэн-Осор хэмээх хоёр өөр нэр гарч буй. Гэхдээ энэ нь нэг л хүнийг хоёр янзаар нэрлэснийх бололтой. Магсар хурц уг үйл явдал чухам хэзээ болсныг огт тэмдэглээгүй бол Л.Дэндэв 1900 онд хэмээн тодорхой хугацаа заажээ. Энэ хоёр түүхч 1925, 1934 онд ийнхүү бичсэнийг судлаачид төдий л хайхраагүй учраас зохиол бүтээлдээ энэ талаар огт авч үзэж байсангүй. Харин 1930-аад оны эхээр Монголоос Хятад руу дүрвэж хожим нь АНУ-д шилжин суурьшсан Дилав хутагт Баашлуугийн Жамсранжавын 1960-аад оны эхээр бичсэн дуртгалд байгаа мэдээ нь Магсар хурц, Дэндэв хоёрын өгүүлснийг нилээд тодруулах боломж олгож байгаа юм. Түүнд тэмдэглэхдээ “Чин Улсын бадруулт төрийн хорьдугаар он бөгөөд 1895 онд” Богд гэгээнтэн Их хүрээнд сууж байсан Оросын консул

И.Я.Шишмарёвой “хэлэлцэж уламжлан Цагаан хаанаас зөвшөөрөл олж Оросын цагаан хаанд бичиг бэлэг сэлтийг хүргэн бариулж дашрамд Монголыг Манжийн захиргаанаас гарч тусгайдаа улс болох явдалд Орос улсаас туслахыг гуйхаар тус шавийн да лам Бадамдоржийг нууцаар явуулсанд Бадамдорж тушаалын ёсоор явж цагаан хаанд бараалхан бичиг бэлгээ барьсанд Хаанаас тусгайлан нэгэн ихээхэн сайдыг томилж аливаа хэргээ түүн лүгээ хэлэлц хэмээснээр Да лам тэр сайдад уг хэргээ хэлж гуйсан зүйл нь:

1. Манай Монгол болбоос эрт урьдаас Чин Улсын Энх-Амгалангийн үе хүртэл өөрийн газар шороогоо өөрөө эзэлж байсан тэр мэтээр эдүгээ Чин Улсаас тусгаарлан өөртөө улс байгуулахыг завдаж баймуй. Тийнхүү босоход Орос Улсаас тусланж бүтээмү.

2. Тэр цагт хэрвээ Чингийн цэрэг дайлаар ирвээс зэвсэг туслах ба Монголын хүчин мөхөсдөх болбоос цэргээр тусалму.

3. Орос Улсаас Манж Улсад Монгол тусгаар улс болох нь зүйтэй учир мөн хэмээн хэлж шууд зөвшөөрөл олгуулму.

4. Монгол нутгийг Цагаан хэрмээр зах хязгаар болгон хуучин Монголын нутгийг бүрнээр эзлүүлмү.

5. Эдүгээ хүрээнд /Нийслэл хүрээ 3.Л/ сууж буй Шишмаревыг хэвээр удаан суулгаж Монголын хэрэгт туслуулму хэмээн бичгийн дотор байх ба эдгээр зүйлийг цөм тайлбарлан хэлсний хариуд Орос Улс бичгийг зөвшөөрөн хүлээж авав” /6.79-80/ хэмээн нилээд дэлгэрэнгүй бичжээ. Магсар хурц Дэндэв нарын бүтээлд энэ тухай тун хураангуй тэмдэглэсэн бол Б.Жамсранжав ямар нэгэн бичмэл сурвалжийг шууд хуулбарлан авч тэмдэглэсэн бололтой байна.Үүнээс гадна Г.Бадамдорж Орост очмогцоо Цагаан хаантай уулзаж ярилцаж зорьж ирсэн хэргээ танилцуулсан ба Богд гэгээнтний хүсэлтийг хэрхэн шийдвэрлэхийг тусгай хүмүүст даалган судлуулж зохих хариу бэлтгүүлсэн нь Б.Жамсранжавын дуртгалд тун тодорхой байна. Богд Жибзундамбын хүсэлт нь тухайн үед огцом буюу эрс шийдвэрлэх боломжгүй олон улсын харилцааны асуудал хөндөхүйц байсан учраас Хаант Орос нилээд болгоомжтой хандах ёстой хэмээн үзсэн нь илэрхий байна.Тиймээс ч ”Монголын явдал зүйтэй болох тул ёстойгоор тусалмой. Энэ тухай Манж Улсад буруу явдал дэмий үгүй тул

хэдэн жил хүлээж шалтаг тохиолыг үзэж босвоос болмой.Тэр цаг бол маш нууцаар яаралгүйгээр бэлтгэх хэрэгтэй” /6.80/ “Консул Я.И.Шишмаревыг туслуулан суулгаж болно.Чухал явдал байваас манай консул лугаа зөвлөж уламжилбаас сайн хэмээжээ” /6.80/ гэж бичсэн байна. Үүнээс ажиглахад Хаант Орос Улс Монголчууд Манжийн эрхшээлээс ангижрахын төлөө олон жил тууштай тэмцэж буйг дэмжиж байсан нь эргэлзээгүй боловч Манжтай сөргөлдөхгүйг хичээхийн сацуу монголчууд Манжийн эсрэг босохдоо хамгийн зохистой цаг үе буюу шалтгийг сонгох нь чухал гэж зөвлөсөн ажээ. Бас Богдоос ингэж Орост хандсан явдлыг тэр үед Богдын багш Ёнзон хамба лам, Жалханз гэгээн, Сайн ноён хан /Цэрэндондовын Төгс-Очир байх 3.Л/, Цэрэндорж нараас өөр хэн ч мэдээгүй хэмээн Б.Жамсранжав бичсэн нь уг үйл явдал маш нууц байдалд явцуу хүрээнд болж өнгөрсөнийг нотолж байна.Энэ нь ч аргагүй юм. Тэр үед Монголын эрх мэдэлтнүүдийн зарим нэг нь Манжийн төрийн бодлогод үнэнч байж эрх мэдэл албан тушаалаа алдахгүйн тулд Оростой ойртох нь тун осолтой хэмээн болгоомжилж байв.Энэ тухай түүхчид бичсэн байдаг. Жишээ нь 1905 онд Орос Японы дайн дууссаны дараа Манжуур дахь Оросын армийн штабын офицер В.Новицкий Сэцэн хан аймаг дайран өнгөрөхдөө Сэцэн хантай (Цэрэндоржийн Дэмчигдоржтой 3.Л) уулзах гэж нилээд хичээсэн боловч тэрбээр “насан өндөр, өвчин эмгэгтэй болсон, ер хэнийг ч хүлээж авдаггүй хаашаа ч явдаггүй, саяхан хүртэл Богд гэгээн Жибзундамба хутагтын урилгаар долоон хошуу наадамд хүрээ орж ч чадсангүй гэх мэт шалтаг зааж ер уулзахыг зөвшөөрсөнгүй аж” /13.236/

Манжийн төр Монголчууд Оросын ард түмэнтэй ойртох нь яваандаа улс төрийн ямар ч сөрөг үр дагаварт хүргэж болзошгүй хэмээн цагдан мөрдөж байсныг Богд хутагт сайн мэдэж байсан учраас тэгж нууцалсан байх нь зүйн хэрэг билээ.

Хоёр. Ш.Сандаг, Ш.Б.Чимитдоржиев, Е.А.Белов,
Л.Жамсран, О.Батсайхан нар энэ тухай бичсэн нь

Магсар хурц, Дэндэв, Жамсранжав гурвын тэмдэглэсэн дээрх мэдээг судалгааны эргэлтэд анх оруулж зохих дүгнэлт хийсэн хүн бол түүхч Ш.Сандаг юм.Тэрбээр 1968 онд БНМАУ-ын түүх” гурван боть зохиолын дэд ботид энэ тухай өгүүлж “Улиастайд цэргийн бослого гарсан 1900 онд Монголын хар, шар

феодалууд Манж хятадын дэглэмийг эсэргүүцэж тусгаар тогтносон феодалын Монгол Улсыг Хаант Оросын тусламжтайгаар сэргээн байгуулах талаар арга сүвэгчилжээ. Ийнхүү Монголын тусгаар тогтнолын хөдөлгөөнд хамрагдсан Богд гэгээн тэргүүтэй том феодалууд өөрсдийн дотроос да лам Бадамдорж, донир лам Цэрэн-Одсэр нарыг 1900 онд Петербург хотноо сэм зарж Чин Улсаас салж тусгаар улс байгуулах хэрэгтээ Оросын Цагаан хаанаас тусламж гуйлгасан юм. Тэр үед Хаант Орос... Манжуурт гол анхаарлаа хандуулж байсан учир Бадамдорж нарын зарагдан очсон хэргийг олигтой дэмжсэнгүй талаар өнгөрүүлжээ” /5.404/ гэж дүгнэсэн байна. Мөн Манж Чин улс шинэ засгийн бодлогыг Монголд хэрэгжүүлж эхлээд байсан нь “Хаант Оросын нөлөөнд ямар аюултай зүйл болох нь сайн мэдэгдээгүй байсан бөгөөд энэ нь Монголын тусгаарлах хөдөлгөөнийг Хаант засгийн зүгээс шууд дэмжихгүй байх бас нэг шалтгаан болсон бизээ” /5. 404/ хэмээн өөрийнхөө дүгнэлтийг тайлбарлажээ.

Дээрх зохиолоос гурван жилийн дараа Ш.Сандаг түүхч туурвисан нэгэн томоохон бүтээлдээ мөнөөх Г.Бадамдорж нарыг Санкт Петербургт илгээсэн тухай дурдахдаа тэдний орчуулагчаар Агын буриад Намдагдэлэг явсан тухай шинэ мэдээг нэмсэн нь /13.222/ уг асуудлыг гүнзгийрүүлэн судлахад зохих дөхөм үзүүлж байна. Гэвч олонхи хүмүүсийн өгүүлсээр ирсэн Бадамдорж, Цэрэн-Осор нар гэдгийг Ш.Сандаг түүхч гурван хүн буюу “Бадамдорж, Донир лам Цэрэн мөн Одсор нарыг” /13.222/ илгээжээ хэмээн бичсэн нь илэрхий ташаарсан бололтой.

Ийнхүү Богд 1900 онд Г.Бадамдорж нарыг Орост илгээсэн тухай мэдээ нь Монгол-Оросын улс төрийн харилцааны түүхийг нэхэн судлахад нэн чухал учир холбогдолтой тул гадаадын эрдэмтэд ч анхааран судалж байлаа. Тухайлбал ОХУ-ын эрдэмтэн монгол судлаач Ш.Б.Чимитдоржиев 1987 онд Орос, Монголын харилцааны түүхийг тусгайлан судалсан бүтээлдээ Нударгатны бослогын үеэр Монголын ноёд Орос улсад түшиглэн Манж Хятадын дарангуйллаас ангижрахыг эрмэлзсэн юм. Тиймээс ч 1900 онд Шанзудба Бадамдорж тэргүүтэй төлөөлөгчид Петербургт ирж II Николай хаанд “Үлэмж бэлэг ба бие даасан Монгол Улс байгуулахад тусламж дэмжлэг үзүүлэхийг хүссэн захидал авчирсан бололтой” /14.130/ гэж дурдсан байдаг. Гэтэл Ш.Б.Чимитдоржиевийн ингэж

бичсэнийг ОХУ-ын монгол судлаач эрдэмтэн Е.А.Белов үндэслэл муутай хэмээн үзэж байгаагаа илэрхийлжээ.Түүний бичсэнээр бол Г.Бадамдорж нар Орост очсоныг нотлохуйц ямарч сурвалж ОХУ-ын архивиудаас олдоогүй ажээ /2.194/ Түүнээс гадна Я.И.Шишмарев тухайн үед хэд хэдэн удаа Оросын Гадаад хэргийн яаманд бичсэн мэдээлэлдээ дурдсанаар бол Жибзундамба хутагт тэр үед Хятадын эсрэг санаа бодол ер агуулаагүй харин ч Бээжингийн засгийн газарт хүндэтгэлтэйгээр хандаж байсан ба Хутагтын баруун гар болсон Бадамдорж түүний зөвшөөрөлгүйгээр бие дааж улс төрийн ямар ч алхам хийх чадваргүй байлаа. Ер нь Бадамдорж Хятадын талыг дэмжсэн байр суурьтай байсан нь хожим тодорхой болсон билээ.Тэгэхээр **“Чимитдоржиевийн ашигласан сурвалж нь /Монгол Улсын түүхийн төв архивын орчуулгын сан хөмрөгт байсан материал/ түүнийг эндүүрэхэд хүргэсэн бололтой”** /2.194/ гэж тэмдэглэсэн байна. Гэвч миний бодоход Ш.Б.Чимитдоржиев энэ талаар ер эндүүрсэнгүй, харин Е.А.Белов өөрөө арай өнгөц таамаглал хийсэн бололтой. Энэ нь 2002 онд түүхч О.Батсайханы зохиолд бичсэнээс болон сүүлийн үед илэрсэн нэгэн сурвалжаас тодорхой мэдэгдэж байгааг хэдхэн мөрийн дараа өгүүлье.

Г.Бадамдорж 1900 онд Санкт Петербургт очсон явдлыг доктор Л.Жамсран 1992 онд нэгэн бүтээлдээ хураангуй өгүүлээд **“Жибзундамба хутагт Орос Улсаас тусламж эрэхээс өмнө Манж хятадын дарлалаас хэрхэн ангижрах талаар ар өвөр монголчууд хамтран чармайж өөрөөр хэлбэл үндэсний эрх чөлөөний тэмцэл эхлээд байж. Иймд тэд Жибзундамба хутагтын нөлөөг ашиглахын тулд түүний нэрээр Орос улсаас тусламж гуйж байсан болов уу”** /9.39-40/ гэж эргэцүүлж байгаагаа тэмдэглэжээ. Л.Жамсран докторын энэ гаргалгаа нь нэг талаар зөв байж болох мэт авч нөгөө талаас нь үзвэл Б.Жамсранжавын бичсэнээр бол Хаант Орост Г.Бадамдорж нарыг маш нууцаар илгээснийг Богд болон түүний тун ойр дотнын хэдхэн хүн мэдэж байснаас үзэхэд хэсэг нөхөд Богдын “нөлөөг ашигласан” бус харин Богд гэгээн өөрөө Монголын тусгаар тогтнолын төлөө их үйл хэргийг сэдэж өөрийн багш болон дотно нөхөдтэйгээ хамтран зөвлөж консул Я.Т.Шишмаревоор дамжуулан өөрийн бие төлөөлөгч Орост илгээсэн болов уу хэмээн үзэж болмоор санагдаж байна.

Г.Бадамдорж нар Орост одсон тухай мэдээг тодруулахад доктор О.Батсайхан зохих нэмэр оруулсан юм. Тэрбээр ОХУ-ын архивын сан хөмрөгт буй сурвалжид тулгуурлан бичихдээ “1898, 1900 онуудад Богд Жибзундамба хутагтаас Хаант Орост хандаж мөнгө зээлэх нэрийн дор да лам Бадамдорж, донир лам Цэрэн-Осор нарыг Петербург руу нууцаар илгээж Оросын хаанд захиа бэлэг сэлтийг хоёр ч удаа хүргүүлж Монголыг Манж Чин улсаас салгаж, тусгаар улс байгуулахад тусламж дэмжлэг үзүүлэхийг хүсэж байсан бөгөөд Оросын хаан Богд гэгээний хүргүүлсэн бичигтэй танилцаад 1900 оны нэгдүгээр сарын 28-нд түүн дээр “ИСПОЛНИТЬ” хэмээн цохолт хийсэн сурвалж ОХУ-ын архивт /Российский государственный исторический архив фонд.560, оп. 28, ед.хр. 176, с.16/ байгааг мэдээлсэн байна. /18,24/ гэж бичсэнээс үзвэл түүхч эрдэмтэн Е.А.Беловын таамаглалыг дахин эргэж харахад хүргэж байна.

Үүнээс гадна Жибзундамба 1900 онд Орос руу хүн зарж илгээснийг нотлохуйц нэгэн мэдээг би олсон юм.Түүнд өгүүлэхдээ “1900 онд иргэн Хятад Улсад гаминдаа байх үест шанзудба-ын яамны лам Бадамдорж, өрлүүдийн аймгийн Цэрэн-Очир зайсан” нар “Богдод айлтгаж зөвшөөрлийг аван Монгол Улсыг тусгаар эрх олгож болох эсэх явдлыг Оросын хаад нууц гарч (хилээр сэм нэвтэрч гэсэн санаа байх 3.Л) учрыг нэвтрүүлэхээр явах үест Агын буриад Намдагдэлэгийн биеийг хэлмэрч болгон мөн миний нэгэн ахыг зарлага болгон Орос гүрний газар гарч (очиж 3.Л) хан, ван, засгийн газруудад учир явдлаа мэдүүлсэнд их хэрэг болгон тоошоохгүй (тоохгүй 3.Л) нэгэнт бурхан шашны талаар төр байгуулахад бэрхтэй ... сүүлд болно хэмээн буцаасан” (3.9) ба түүнээс хойш “Бадамдорж Орос улсыг ер бүтэхгүй этгээд нар мөн хэмээн бодож явсаар” (3.10) 1911 онтой золгосон гэж өгүүлжээ.Энэ тухай бичсэн хүн бол тухайн үеийн Сэлэнгэ аймгийн Алтанбулагийн харьяат Дамбадугар, Цэдэпов юм.Түүний бичсэн энэ зүйл нь Богдын улс төрийн үйл ажиллагааг ялангуяа 1900 онд Г.Бадамдорж, Цэрэн-Осор нар Богдын зөвшөөрлөөр Орост очиж Монголыг Манжаас ангижран тусгай улс болгож болох эсэхийг Оросын эрх мэдэлтнүүдээс лавлаж улмаар тусламж эгээрсэн боловч зорьсон хэргээ бүтээж чадаагүйг тодруулахад дөхөм болж байна.

**Гурав. 1911 онд Богд гэгээн Орос хандаж тусламж
хүссэн тухай асуудлыг тодруулахуй**

1911 оны Монголын үндэсний хувьсгалын түүхэнд Богд Жибзундамба чухам ямар үүрэг гүйцэтгэснийг 1990 оноос өмнөх түүхчдийн бүтээлд төдийлэн авч үзэж байсангүй.

Харин 1990 оноос хойш Богдын тухай судалгаа нэлээд гүнзгийрч түүнийг 1911 оны хувьсгалын удирдагч байлаа хэмээн дүгнэх боллоо. Иймд энэ асуудлыг судлаачид хэрхэн авч үзэж байгааг хураангуй өгүүлье.

1911 оны зургадугаар сард Монголын Сайн ноён хан Т. Намнансүрэн нууц захидал бичиж Богд гэгээнтэнд толилуулахдаа Манжаас халхад хэрэгжүүлж буй шинэ засгийн бодлого нь ноцтой аюул учруулж буйг цохон дурдаад **“Дөрвөн аймгийн хан, ван, ноёдын зөвлөлгөөнийг Их хүрээнээ хуралдуулж хятадууд Монголыг эцэс төгсгөл болтол нь боолчлон дарангуйлж буйг эсэргүүцэн хэлэлцэх шаардлагатайг хүссэн байна”**. (2.35-36) Богд энэхүү захидалтай танилцмагцаа лүндэн буулгаж мөн оны долдугаар сарын дундуур халхын ноёдыг Их хүрээнд ирүүлэх зарлал тархаажээ. Энэ тухай мэдээг тэр үед хүрээнд сууж байсан орос консул В. Лавдовский сонсож мэдээд Богдтой биечлэн уулзаж удахгүй хуралдах зөвлөлгөөний тухай лавлан сонирхсон байна. Тэгэхэд Богд хутагт өөрийн байр сууриа илэрхийлж, хэрэв манай ноёдын **“зөвлөлгөөнөөс шинэ засгийн бодлого нь монголчуудыг боолчлон дарахад чиглэж байгааг хүлээн зөвшөөрөх аваас Халхад байгаа бүх хятад цэргийг гаргаж бүх шинэчлэлээ халахыг Чин Улсаас шаардах болно. Хэрэв эдгээр шаардлагыг биелүүлэхээс татгалзвал түүнийг бүхий л аргаар хэрэгжүүлэх болно. Эцсийн эцэст зэвсгийн хүчээр эсэргүүцэх харь гүрнүүдэд юуны өмнө Орос Улсад хандаж Монголыг өмгөөлөлдөө авахыг хүсэх болно”** /2. 36/ гэж хариулсан байна.

Үүний дараахан мөн оны долоодугаар сарын 27-28-нд Халхын Сэцэн хан, Сайн ноён хан, Засагт хан аймгийн гурван хан ба хорин гурван засаг ноёд хэд хэдэн лам нар Жибзундамбын удирдлагын дор нууцаар хуралдаж **“Манж улсын төрийн шинэ бодлого Монголын ард түмний санаа сэтгэлийг харгалзан цаашдаа манж улсын харьяанд байж болохгүй”** /4.247-248/ гэж шийдвэрлэсэн боловч Манжийн эрхшээлээс ангижрахын тул олон асуудлыг тухайлбал аль улсын

тусламжид түшиглэх Манжийн эсрэг тэмцэж эхэлмэгц Хятадууд их цэрэг авчирвал яах вэ гэх зэргийг хэрхэн шийдвэрлэхийг Богдод айлтгахад тэрбээр “**Та нар улс байгуулж Монгол юугаа амар тайван болгох санаа байвал цэргийг /Манжаас цэрэг ирвэл 3.Л/ буцаахыг би мэдмүй**” /6.82/ гэж зарлиг буулгажээ. Ингэж тус зөвлөлөгөөнд оролцогчдын сэтгэлийг хамгийн ихээр зовоож байсан зүйлийн нэг тийш нь болгож өгчээ. Иймээс тэрхүү зөвлөлөгөөнд оролцогчид Монгол Улс Манжаас тусгаарлан бие даасан улс байгуулах тэмцэлдээ “**Орос Улсаас тусламж гуйх хэлэлцээ хийх тусгай төлөөлөгч одуулах шийдвэр гаргажээ** /4.248/

Ийнхүү шийдвэр гаргахад Богд Жибзундамба маш том үүрэг гүйцэтгэсэн байна. Иймд энэ талаар зарим зүйлийг тодруулья. Богд Жибзундамба яаагаад ийм итгэлтэй мэдэгдсэн нь сонирхол татаж байна. Миний бодоход тухайн үеийн Монголын улс төрчид Хаант Орос Манж Чин Улсын гадаад бодлогыг ихээхэн сонирхож 1905 онд Орос Японы дайнд Хаант Орос ялагдаж 1907 онд Орос Япон хоёр улс хэлэлцээр байгуулж Монголын чухам аль аль бүс нутагт эрхшээл нөлөөгөө тогтоохоор тохиролцсон ба 1907 оны наймдугаар сарын 31-нд Петербургт Оросын Гадаад хэргийн сайд А.П.Извольский Британийн элчин А.Никольсон нарын гарын үсэг зурсан Англи-Оросын хэлэлцээрээр Дундад Дорнод дахь нөлөөний хүрээг тогтооход Түвэдийг Английн нөлөөнд Монголыг Оросын нөлөөнд хуваасныг /10.45/ Богд ба Монголын бусад ихэс дээдэс сайн мэдэж байсан учир Манжийн төр Монголыг өөрөөсөө алдахгүйн тулд эрх чөлөө тусгаар тогтнолынхоо төлөө тэмцсэн монголчуудын эсрэг цэрэг хөдөлгөх аваас Хаант Орос хандахад туслах нь лавтай хэмээн ухаарч Богд Жибзундамба дээрх үгийг хэлсэн бололтой.

Дээрх ноёдын хурлаас гаргасан шийдвэртэй мөнөөх В.Лавдовский танилцаад Петербургт цахилгаан утас илгээж “**Халх Монгол Оросын ивээл хамгаалалд орохыг гуйсан бичгийг Цагаан хаанд барих ба шинэ Монгол Улсад Оросын зүгээс тусламж эрэх хэлэлцээр хийх бүрэн эрхтэй төлөөлөгч мөдхөн их хүрээнээс Орос орно**” /4.248/ хэмээн мэдэгдсэн байна.

Хаант Оросын Засгийн газар энэ цахилгааныг хүлээн авч хэлэлцэхдээ “**жаахан эргэлзэж байгаад тэр үед Оросын ерөнхий сайдын үүрэг гүйцэтгэгч байсан Нератовт хандаж**” Энэ явдлыг бидэнд ашигтай болгохын учир...

Монголын төлөөлөгчдийг хүлээн авья гэж зөвшөөрчээ” /4, 248/. Үүний дараа Оросын Гадаад явдлын яамны сайд хамаарсан А.А.Нератов Бээжинд сууж байсан И.Я.Коростовецид цахилгаан утас илгээж санал бодлоо солилцон Монголын төлөөлөгчидтэй хэлэлцэх зүйл ба өгөх шийдвэрээ зөвлөжээ.

Ингээд Богд ба Халхын дөрвөн ханы хамтран бичсэн захидал мөн түүний хавсралт хорин нэгэн зүйл бичгийг М.Ханддорж нараар Оросын эзэн хаанд хүргүүлж Манжийн эрхшээлээс ангижрахад тусламж үзүүлэхийг хүссэн бөгөөд энэ нь ч уг ёсоор бүтсэн билээ. Энэ бол Жибзундамбаас Орост хандсан хоёр дахь удаагийн явдал байж болох юм. Үүнийг 1925 оноос хойш хэд хэдэн түүхч бүтээлдээ хөндсөөр ирсэн боловч тодорхойгүй зүйл цөөнгүй бий. Тухайлбал, М.Ханддорж нарыг Орост очсоны дараа П.А.Столыпиний саналаар 1911 оны наймдугаар сарын 17-ноос эхэлж Оросын эрх баригчид Монголын хүсэлтэд хэрхэн хариу өгөхөөр хэлэлцсэн хуралдааны талаар нарийвчлан судлах; мөн Богд ба Лавдовский нар тухайн үед уулзаж ярилцсан зүйлийн агуулгыг гүнзгийрүүлэн шинжлэх шаардлага байна.

**Дөрөв. 1921 оны Монголын үндэсний ардчилсан
хувьсгалын өмнө Богд хаан ямар байр суурь
байртай байсан бэ?**

1919 оны эцсээр Дундад Иргэн Улс цэрэг зэвсгээр сүрдүүлэн Монголын автономитыг цуцалж, өөрийн шууд эрхшээлд оруулан захирах болсноос хойш Монголын эгэл ардаас эхлээд ихэс дээдэс хүртэл бүх хүн Хятадын харьяаллаас үтэр түргэн ангижрахыг хичээж элдэв арга эрэлхийлэн байсан тэр үед зарим ноёд лам нар Япон, Америк зэрэг улсад хандаж тусламж дэмжлэг хүсэхээр оролдсон боловч төдий л бүтэлтэй болоогүй аж. Үүний улмаас улс орны хувь заяа хаашаа эргэх нь хутганы ирэн дээр тулсан нэн эгзэгтэй тэр цаг мөчид буюу **“Монголын аравдугаар он хаврын сүүл / 1920 оны дөрөвдүгээр/ сарын эцсээс эхлэн Богд хаантнаас”** зарлиг буулгаж **“Хятадын эрхшээлээс хэрхэн ангижрах аргыг одооноос сүвэгчлэн хэлэлцтүгэй”** /11.168/ гэж Нийслэл хүрээнд байгаа ван гүн лам нарт сануулах болсон байна. Энэ дагууд ноёд түшмэд лам нар зөвлөлдөн хэлэлцэж Нийслэл хүрээний Эрдэнэ шанзудба Дашжав нарын санаачлагаар 1920 оны зун Халхын дөрвөн аймгийн олон хан, ван, гүнгүүдийг бүгдээр Нийслэлд дуудан ирүүлж хуралдуулсан байна. /11.168/ Уг хуралд Хатанбаатар Магсаржав,

Манлайбаатар Ж.Дамдинсүрэн нар оролцсон ба тэд “ Богд хааны дурдсанаар / сануулснаар 3.Л/ Монгол засгийн эрхийг дахин олж авах аргыг хэлэлцээд Орос, Хятадын аль аль нь дотроо дайтаж байгаагийн сацуу Оросын цагаантны зүгээс Монголд “халдаар ирвээс Хятад цэрэг нь Монгол газрын уул ус чухал боомт газрыг мэдэхгүй зэрэгт боогдох мөчдөх зүйл байх тул Монголын / хурааж авсан 3.Л/ цэргийн зэвсгийг эгүүлэн” / 11.169/ олгохыг Сую Шужаныханд хүсэж зэвсэгтэй болъё хэмээн санал гаргаж байжээ.

Тэр үед Сую Шужаныг Бээжингээс дуудсан тул тэрбээр эзгүй байсан боловч түүний цэргийг захирсан Хятад сайд Цойложан, Го Силин нарт дээрх ноёдын хуралдаанд оролцогсод өөрсдийнхөө саналыг уламжилж чадаагүй байна. Гэтэл эдгээр ноёдын энэхүү саналын тухай Сую Шужангийн Яамны ажилтнууд сонсож мэдээд монголчуудыг элдвээр хардаж сэжиглэх болжээ. Дээрх хуралдаан тарсны дараа С.Магсаржав, Ж.Дамдинсүрэн нарын зэрэг цөөн хүн Нийслэл хүрээнд үлдэж 1920 оны зун дээрх хурал эхлэхээс өмнө Сую Шужангийн тушаалаар Гадаад Монгол ДИУ-тай нэгдсэний баярт оролцохоор одсон Жалханз хутагт, Дилав хутагт, Сэцэнхан Наваанцэрэн, ван Пунцагцэрэн, Ширниндамдин, Пунцагравдан, чин ван лам Дашдэндэв, бэйс Цогт-очир, гүн Ламжав нар “Монголын хуучин эрхийг олох арга сүвэгчилж явахаар захисан зүйл” /11. 170/-ийг бүтээсэн эсэхийг түр хүлээхээр сууж байжээ.

Яг энэ үед Нийслэл хүрээнд 1918 оноос хойш нууцаар улс төрийн үйл ажиллагаа явуулж байсан хувьсгалчдын хоёр бүлэг нэгдэж МАН-ыг байгуулан “шашин үндсэнд харшлах харгис дайсныг цэвэрлэж алдагдсан эрхийг эгүүлэн аваад төр шашныг үнэн сэтгэлээр бататган мандуулж үндэс язгуурыг алдагдалгүй сахих ба дотоод засгийг үнэн сэтгэлээр сайжруулан засамжилж ядуу доод ард түмний тусыг туйлаар бодох ба өөрийн дотоод эрхийг өнө үүрд сахиж дарлах дарлагдахын зовлонгүй аж төрөхийг чухал болгоно” /15.54-55/ хэмээн тангараг өргөсөн байна. Тус нам ЗОУ-аас тусламж гуйх төлөөлөгчдийнхөө эхний хэсгийг умар зүг илгээсэн аж. Тус намын төлөөлөгчдийн сүүлчийн хэсэг нь ЗОУ-д тусламжийн хэргээр одох тухайгаа “Богдод айлтгаж зөвшөөрлийн бичигт тамга” /7. 54/ даруулж авсан байна. Энэ тухайд Магсархурц өгүүлэхдээ “Богд хаанаас манай улсын мандах хэрэгт энэхүү ардуудад улаан орос /ЗОУ 3.Л/ тус болмой хэмээн зарлиг буулгаж

олон ван, гүн, лам нарын нэрээр улаан Оросын Засгийн газраа явуулах бичигт мутрын тэмдэг дарж өгсөн зүйл. буй гэдэг” /11.170/ гэжээ.

Үүнээс гадна энэ талаар Х.Чойбалсан, Л.Дэндэв нар болон бусад хүмүүс товч өгүүлсэн байдаг.Өөрөөр хэлбэл, 1920 оны зун МАН-ын төлөөлөгчид ЗОУ-д тусламжийн хэргээр одохыг Богд хаантан зарлиг буулган дэмжсэн нь бодит хэрэг явдал гэдгийг түүхчид үгүйсгээгүй билээ.Гэхдээ 1990 оноос өмнө энэ талаар тусгайлан судлахаас болгоомжилж байв.Харин Монголд ардчилал тууштай хэрэгжих болсноор энэ асуудлыг олон хүн хөндсөн боловч ултай тодруулсан тусгай судалгаа одоо хир алга.Иймээс Богд хаантан 1920 онд Орост гурав дахь удаагаа хандаж Монголын тусгаар тогтнолын төлөө тэмцэлдээ тусламж эгээрснийг улируулан шинжлэх нь олон талын учир холбогдолтой билээ.

Дүгнэлт: Монголчууд улс орныхоо тусгаар тогтнолыг сэргээх их үйл хэргийг удирдаж байсан Богд гэгээнтэн 1895 буюу 1900 онд Хаант Орост хандаж улс төрийн туслалцаа хүсэж байсныг 1925 оноос эхлэн зарим түүхчдийн бүтээлд, мөн 1968, 1985 онд хэвлэсэн БНМАУ-ын түүхийн ботид товч дурдсаныг цаашид ултай судалж нэгтгэн дүгнэх зүй ёсны шаардлага байна.Гэтэл 2003 онд нийтийн хүртээл болсон “Монгол улсын түүх”-ийн тавдугаар ботид энэхүү асуудлыг хэт хураангуйлж “Жибзундамба хутагт Монголын умард хэсгийн зарим аймаг угсаатныг хэдийн өөртөө нэгтгэсэн агаад мөн XIX зууны дунд үеэс Алс Дорнодод идэвхтэй бодлого явуулж Монголыг нөлөөнийхөө хүрээнд оруулахыг зорьж байгаа Хаант Орос улсыг түшиглэн Монголын төрийн тусгаар тогтнолоо сэргээх чин эрмэлзлэлтэй байгаагаа 1895 онд илэрхийлж Оросын эзэн хаанаас тусламж эрэхийн учир Да ламын зэрэг төлөөлөгч илгээн бараалхуулж тусламж эрсэн албан бичиг гардуулж байсан” (121.51) гэж Б.Жамсранжав, Л.Дэндэв нарын бүтээлд буй мэдээг эшлэн ямар нэгэн дүгнэлт хийлгүйгээр өгүүлжээ.

Харин 1911 онд М.Ханддорж нар Орост тусламжийн хэргээр одсон тухай дээрх зохиолд авч үзэхдээ хэд хэдэн сурвалжид тулгуурлан шинэлэг байдлаар өгүүлж **“Монголчуудын үндэсний эрх чөлөөний тэмцлийг Орос улс дэмжих болсон”** (12.56) гэж онцлон дурджээ.Гэхдээ Хаант Орост тусгай төлөөлөгчид илгээж тусламж авч монголчууд Манжаас салж тусгаар улс болох **“санал сэдэж”** (12.54) санаачилсан хүмүүс бол Ханддорж, Чагдаржав, Цэрэнчимэд нар байсан бөгөөд тэд энэ тухайгаа эхлээд **“нууц зөвлөлгөөнд оруулан хэлэлцүүлээд**

улмаар Богд Жибзундамба хутагтаас соёрхлыг олжээ". (12.54) хэмээн дүгнэсэн нь Богд гэгээнтэн 1911 оны Монголын үндэсний хувьсгалд чухам ямар үүрэг гүйцэтгэснийг шууд ойлгох боломжгүй байна.

Үүнээс гадна 1921 оны үндэсний ардчилсан хувьсгалын үйл хэрэгт Богд хаантан ямар байр суурьтай байсан бэ гэдгийг буюу ер нь тэрбээр бага боловч хувь нэмэр оруулсан эсэхийг дурдсангүй. Зөвхөн **"Д.Сүхбаатар ... нар Богдын тамгатай бичгийг авч яаравчлан"** (12.108) ЗОУ-д одсон ба уул бичгийг Ф.И.Гапонд танилцуулсан тухай өгүүлжээ.

Дээр өгүүлснээ нэгтгэж үзэхэд Богд гэгээнтэн XX зууны монголын хоёр хувьсгалын эхлэл, өрнөл, ялалтад болон Монголын улс төрд гүйцэтгэсэн үүргийг тал бүрээс нь нэхэн судлах талаар түүхчид бид цаашид анхаарч даацтай бүтээл туурвих шаардлагатайг цохон тэмдэглэж байна.

Жич: өмнө дурдсан Дамбадугар Цэдэповын тэрхүү өргөдлийг кирилл бичигт буулгаж ойрмог хугацаанд аль нэгэн сэтгүүлд хэвлүүлж судлаачдад толилуулахаар завдан буйг сонордуулъя.

Abstract: In this paper, I tried to clarify that how the XXIII incarnation of Zhevzhundamba khutugtu's great efforts in heroic act for the restoration of Mongolian independence; sent his trustworthy delegation to Russian Empire during the end of 1800s and in 1911, and his political position on the first seven people (delegation) of Mongolian People's Party and their leaving to Soviet Russia for help in 1920 were described in some historians and scholars' writings.

Ном зүй

1. Батсайхан.О Монголын тусгаар тогтнол ба Хятад, Орос, Монгол гурван улсын 1915 оны Хиагтын гэрээ (1911-1916) УБ. 2002
2. Белов.Е.А Россия и Монголия (1911-1919 гг.) М. 1999
3. БНМАУ-ын Бага хурлын газар Дамбадугар Цэдэповын өргөсөн өргөдөл -- Үндэсний төв номын сан. Д (517,3) Д—264, /15.386/ 96, 4777
4. БНМАУ-ын түүх. УБ. 1955
5. БНМАУ-ын түүх. Дэд боть 1604-1917 УБ. 1968

6. Дилав хутагт Б.Жамсранжав. Ариун сэтгэл, авралын үндэс.(дуртгал, намтар, өгүүлэл) УБ. 2000
7. Догсом.Д Ардын намыг байгуулах явдлыг анхан хэрхэн үүсгэн оролцсон тухай- МАХН-ын түүхэнд холбогдол бүхий зүйлүүд (Сийрүүлж нэмсэн хоёр дахь хэвлэл) УБ., 2004
8. Дэндэв.Л Монголын товч түүх. Дөтүгээр дэвтэр. УБ. 1934
9. Жамсран.Л Монголчуудын сэргэн мандалтын эхэн. (1911-1913) УБ. 1992
10. Латтимор.О Нүүдэлчид ба хувьсгалчид. УБ. 1994
11. Магсаржав.Н Монгол улсын шинэ түүх. УБ. 1995
12. Монгол улсын түүх. Тавдугаар боть (XX зуун) УБ. 2003
13. Сандаг.Ш Монголын улс төрийн гадаад харилцаа.1850-1911. УБ. 1971
14. Чимитдоржиев.Ш.Б Россия и Монголия. М. 1987
15. Чойбалсан.Х, Лосол.Д, Дэмид.Г Монгол ардын үндэсний хувьсгалын анх үүсэж байгуулагдсан товч түүх. (Хоёр дахь удаагийн хэвлэл) УБ. 1979